

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХОНГОРЗУЛЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая. төг/	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
				Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1		2	3	4	5	6	7
НЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
1	ЗГҮАХ 1.1.3.2 ЭМССТ-2.4 Шаардлагатай аймгуудад Зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна	3,277.8	Байгуулсан ЗӨСТ болон хилийн боомтын тандалтын нэгжийн тоо	3 аймагт ЗӨСТ, хилийн 12 боомтод тандалтын нэгж байгуулах тооцоо судалгаа хийгдсэн.	2 аймагт ЗӨСТ, хилийн 10 боомтод тандалтын нэгж байгуулсан байна.	ЭМС-ын 2024 оны А/238 тушаалаар АХБ-ны “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх” МОН-9218 төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 2,88 тэрбум төгрөгийн молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийг ЗӨСҮТ болон 14 салбар ЗӨСТөвд хуваарилж, хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан.	I-IV улирал	100%
2	Эрт илрүүлгийн явуулын машины ашиглалтын журам батлуулна.		Батлагдсан тушаал	-	Хамаарах чиг үүргийн судалгааг гаргасан байна.	Нийтийн эрүүл мэндийн газартай хамтран Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/96 дугаар “Түр журам батлах тухай” тушаал батлуулсан. Уг тушаалаар урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх тусгай зориулалтын автомашиныг ашиглах түр журам, автомашин, түүнд суурилагдсан багаж төхөөрөмжийг хүлээлцэх багийн бүрэлдэхүүн, хяналтын хуудсыг баталсан.	I-II, улирал	100%

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

3	ЗГҮАХ 2.1.3.1 Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна.	42,000.0	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2024 онд санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад орж, санхүүжилт батлагдсан.	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлж 10 хувьд хүргэсэн байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/" төсөвт өртөг нь 140.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 42.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр "Магнуссентурион Констракшн" ХХК болон "Сетунари" ХХК-ийн түншлэл шалгаран 140.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Газар шороо, гаражийн барилгын суурь, 1 давхарын цутгалтын ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 10%-тай байна.	I-IV улирал	100%
4	ЗГҮАХ 2.1.3.2 Зүрх судасны төв байгуулна.	1,126.1	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2024 онд санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад орж, санхүүжилт батлагдсан.	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилгын гадна инженерийн шугам, сүлжээний ажлыг эхлүүлж 10 хувьд хүргэсэн байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо/" төсөвт өртөг нь 2.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 1.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг 7 удаа зарласан, 5 удаа оролцогч санал ирүүлээгүй 2 удаа шаардлага хангасан оролцогч санал ирүүлээгүй. ЕСБХБанкны хөнгөлөлттэй зээлээр "Зүрх судасны үндэсний төв"-ийн барилгын төслийг санхүүжүүлэхээр 2024.09.30-ны өдөр МУ-ын ЭЗХЯам, СЯ, ЭМЯ болон ЕСБХБанк хамтарсан DTM55677 дугаартай "Санхүүжилтийн өмнөх гэрээ"-г байгуулсан. Уг гэрээний дагуу 120 ортой тусгай зориулалтын ЗСҮТөвийн барилга барьж ашиглалтад оруулах төслийн нийт өртөг 51,0 сая ам.доллар байх ба ЕСБХБанк нь 30,0 сая ам.долларыг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ. Тоног төхөөрөмжийн нийт өртөг 21,0 сая ам.доллар байх ба улсын төсөв болон	I-IV улирал	100%

						Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэхээр тооцоолсон. Мөн ЕСБХБанкны "Техникийн хамтын ажиллагааны сан"-аас төслийн "Техник эдийн засгийн үнэлгээ", – "Байгаль орчин, нийгмийн үнэлгээ", "Худалдан авалтын үйл ажиллагаанд түр хугацааны дэмжлэг үзүүлэх", "Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих" зэрэг үйл ажиллагаанд 1,1 сая еврогийн буцалтгүй тусламжийг үзүүлнэ.		
5	ЗГҮАХ 2.1.3.4 Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	315.6	Барилгын гүйцэтгэлийн хувь	2023 онд барилга угсралтын ажил 85 хувьтай байна.	Эмнэлэг ашиглалтад орсон байна.	Барилга угсралтын ажлын зураг төсөл, төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нь нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/"-ын ажлыг дуусган Геронтологийн төв болгон ашиглахаар төлөвлөж байна. Ажлын гүйцэтгэл 95%-тай явж байгаа бөгөөд улсын комисс ажиллуулах хүсэлтээ өгсөн. 2024 оны 12 дугаар сарын 2 дугаар 7 хоногт ажиллах улсын комиссын хуваарьт оруулахаар ажиллаж байна.	I-IV улирал	95%
6	ЗГҮАХ 2.1.3.6 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна.	4,002	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2024 онд санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад орж, санхүүжилт батлагдсан.	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилгын гадна инженерийн шугам, сүлжээний ажлыг эхлүүлж 10 хувьд хүргэсэн байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчээр "Эм Си Эс Си" ХХК болон "Солармед Монгол" ХХК-ийн түншлэл шалгаран гэрээ	I-IV улирал	100%

						байгуулсан. Гадна инженерийн шугам, сүлжээний газар, шорооны ажил, барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан, байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 25%-тай байна.		
7	ЗГҮАХ 2.1.3.7 Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна.	10,000.0	Батлагдсан ТЭЗҮ Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ	2024 онд санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад орж, санхүүжилт батлагдсан.	Зураг төсөв, ТЭЗҮ-г дуусган, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.	Хавдар судлалын үндэсний төв-2 цогцолбор байгуулах зориулалтаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Чулуутын аманд 10 га газар олгогдож, зураг төслийг БХБЯаманд захиалж, 2021 оноос зураг төсөл, төсөв боловсруулах гэрээ байгуулагдсан боловч, зургийн ажлын явц 30 хувьтай байна. Ажлын зураг төсөл, төсвийн гүйцэтгэгч "Хот Төлөвлөлтийн Хүрээлэн" ХХК 996.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч загвар зураг батлагдсаны дараа тухайн гэрээний дүнгээр гүйцэтгэх боломжгүй 3,800.0 сая төгрөгөөр гүйцэтгэх тухай санал ирүүлж, зөвшөөрөхгүй тохиолдолд гэрээ цуцлах хүсэлт гаргасан. Гүйцэтгэгчийн саналыг захиалагч Барилга, хот байгуулалтын яамнаас судлан 3,800.0 сая төгрөг биш нэмэлт 3,000.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоолол гарган санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад хандсан. 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн "Жагсаалт батлах тухай" А/12 дугаар тушаалаар нэмэлт хөрөнгө шийдвэрлэж, Эрүүл мэндийн яамнаас худалдан авах ажиллагааг зарлуулахаар Төрийн Худалдан авах ажиллагааны газарт холбогдох мэдээллийг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2/1692 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр "Бодь пропертийз" ХХК болон "Төгс гранд констракшн" ХХК-ийн түншлэл 2,400.0 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулсан.	I-IV улирал	80% 

22

						УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 3.3.2.3. "Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II"-ын барилга барих гэж 20,000.00 сая төгрөг тусгагдсан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Хавдар судлалын үндэсний төв-2 төсөл арга хэмжээнд 10,000.0 сая төгрөг батлагдсан. Худалдан авах ажиллагааг зохион байгууллахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -д төсөл, арга хэмжээг үүсгээд байна.		
8	ЗГҮАХ 2.1.3.8 Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барьна.	5,000.0	Худалдан авах гэрээ	2024 онд санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад барилга худалдан авах 40 тэрбум төгрөг батлагдсан.	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, худалдан авах гэрээг байгуулсан байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад "Эмнэлгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо/" төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 40.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 5.0 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд Засгийн газрын 2023 оны "Жагсаалт батлах тухай" 409 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/12 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн. Нийслэлээс худалдан авах ажиллагааг 2024.04.18-ны өдөр зарласан боловч "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар"-т гомдол гарч, худалдан авах ажиллагаа түр зогссон байсан нь шийдвэрлэгдсэн. Дахин зарласан тендерийн нээлт 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр болж оролцогч санал ирүүлээгүй тул амжилтгүй болсон.	I-IV улирал	30%
9	ЗГҮАХ 2.1.4.2 Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн	4,200.0	Чадавхыг бэхжүүлсэн лавлагаа шатлалын	2023 онд 910.8 сая төгрөгийн хүчилтөрөгчийн аппаратыг эрүүл	Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын	Эрүүл мэндийн 2024 оны сайдын багцын хөрөнгө оруулалт ба нөөц хөрөнгөнөөс эрүүл мэндийн байгууллагын 163 байгууллагад 33 нэр төрлийн 7,425.1 сая	I-IV улирал	100%

	чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.		эрүүл мэндийн байгууллагуудын тоо	мэндийн 9 байгууллагад нийлүүлсэн.	яаралтай тусламжийн чадавх бэхжсэн байна.	төгрөг, ийн өвчтөний хяналтын монитор, тариурын автомат шахуурга, дуслын автомат шахуурга, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, мобайл тоног төхөөрөмж, зөөврийн эхо, эмэгтэйчүүдийн үзлэгийн ор гэх мэт яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах тоног төхөөрөмжөөр хангасан байна. Мөн Өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байдалтай байсан алслагдсан орон нутгийн 60 эрүүл мэндийн төвд Засгийн газрын 2024.02.16-ны 63 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр эмнэлгийн яаралтай туулах чадвар сайтай 60 автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж болох дефибриллятор (монитортой), отсос, хүчилтөрөгчийн баллон 10л, яаралтай тусламжийн таних тэмдэг бүхийн 1,486.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.		
10	Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн цэг байгуулна.		Яаралтай тусламжийн цэгийн тоо	2023 оны байдлаар яаралтай тусламжийн 10 цэгийг байгуулсан.	Орон нутагт шаардлагатай 40 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулагдсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 21 аймгийн эрүүл мэндийн газарт яаралтай тусламжийн багцийг хуваарилсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/267 дугаар тушаалаар 20 сум, өрхийн эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, түргэний машиныг хуваарилсан. Аймгууд сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Төв аймаг, Хөвсгөл аймгийн Жанхайн даваа, Булган аймгийн Хутаг өндөр, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хөвсгөл аймаг Мөрөн сум, Өвөрхангай аймаг Өлзийт сум, Дундговь аймаг Баянцагаан сум, Өмнөговь Дэлгэрцогтсум, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Сэлэнгэ аймгийн Сант сум тус тус сумны эрүүл мэндийн төвийг	I-IV улирал	100%

						түшиглэн “Хар цэг” ойролцоох нутаг дэвсгэрт Яаралтай тусламжийн цэгийн байгуулан ажиллаж байна. Дээрх сумын эрүүл мэндийн байгуулагуудад 680 гаруй иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Яаралтай тусламжийн цэгийг байгуулснаар тусламж, үйлчилгээний үзүүлэх хугацаа багассан үр дүн гарсан.		
11	ЗГҮАХ 2.1.4.4 Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.	9,000.0	Шинээр байгуулагд-сан эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	2023 оны жилийн эцсийн байдлаар 19 аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн 5 эмнэлэг, 4 дүүргийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийг дэмжих төвтэй байна.	2 дүүрэг, 2 аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн дэмжих төв байгуулна.	1. Бүгд Найрамдах Польш Улсын “Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх” төслийн хүрээнд 17,5 тэрбум төгрөгийн бүрэн тоноглогдсон 35 түргэн тусламжийн автомашин нийлүүлэгдэж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/116, А/212, А/228, А/229, А/264, А/280, А/327 дугаар тушаалаар 6 төв эмнэлэг, 3 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. 2. Дэлхийн банкны “Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/195, А/400, А/454 дугаар тушаалаар 55 түргэн тусламжийн автомашиныг 13 аймгийн 53 сумын эрүүл мэндийн төвд, АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт хуваарилан олгосон. 3. Засгийн газрын 2024.02.16-ны 63 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр өвөлжилт хүндэрсэн орон нутгийн байгууллагуудад эмнэлгийн зориулалттай, туулах чадвар сайтай 60 автомашиныг Эрүүл мэндийн сайдын А/104, А/127 А/188 А/267 дугаар тушаалаар хуваарилсан. (Архангай аймгийн Батцэнгэл, Өндөр-Улаан, Хангай, Чулуут, Хайрхан,	I-IV улирал	100%

					Өлзийт, Эрдэнэмандал, Цэнхэр сум, Баян-Өлгий аймгийн Булган, Цэнгэл сум, Булган аймгийн Хишиг-Өндөр сум, Баянхонгор аймгийн Баянговь, Баянбулаг, Баян-Овоо, Бууцагаан, Баян-Өндөр, Галуут сум, Сэлэнгэ аймгийн Орхон, Номгон, Шаамар сум, Завхан аймгийн Баянтэс, Дөрвөлжин, Их-Уул сум, Өвөрхангай аймгийн Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Хайрхандулаан, Сант сум, Төв аймгийн Баяндэлгэр, Баянцогт, Аргалант сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Чандмань-Өндөр, Ренчинлхүмбэ Цэцэрлэг сум, Говь-Алтай аймгийн Тайшир, Жаргалан, Халиун сум, Дундговь аймгийн Өлзийт сум, Увс аймгийн Тэс сум, Ховд аймгийн Алтай, Ховд сум, Хэнтий аймгийн Батноров, Баян-Адарга, Биндэр Дархан сум) 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 31 эрүүл мэндийн байгууллагын туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашин худалдан авах 4.2 тэрбум төгрөгийн төсвийг хуваарилан олгосон байна.	
--	--	--	--	--	---	--

12	ЗГҮАХ 2.1.5.1 МУХТЖҮЧ 2.2.1 Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна.	1,435.0	Шинээр байгуулагдсан эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	2023 оны жилийн эцсийн байдлаар 19 аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн 5 эмнэлэг, 4 дүүргийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийг дэмжих төвтэй байна.	2 дүүрэг, 2 аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн дэмжих төв байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 21 аймаг, 5 дүүрэгт "Эрүүл мэндийг дэмжих төв" байгуулах төслийн хүрээнд нийт 36,4 тэрбум төгрөгийн барилгын засварын ажил хийгдэж, эмнэлгийн тоног төхөөрөмж (суурин дижитал рентген аппарат, суурин болон зөөврийн эхо, дурангийн оношилгооны иж бүрдэл, тархины цахилгаан бичлэгийн аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, чих хамар хоолойн болон шүдний оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, нүдний оношилгооны тоног төхөөрөмж, биеийн бүтэц тодорхойлох аппарат, үзлэгийн ор, тэргэнцэр, эмнэлгийн тавилга, ширээ сандал) нийлүүлэгдэж, үйл ажиллагааг эхлүүлсэн.	I-IV улирал	100% (198)
13	"Алсын хараа-2050" 2.2.26, ЗГҮАХ 2.1.8.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.	500.0	Тогтмол баяжилт хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж-жийн бүртгэл	2023 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программд 588 эрүүл мэндийн байгууллагын 1,181 хэрэглэгч, 31,163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд тогтмол баяжилт хийсэн байна.	Бүгд Найрамдах Польш Улсын "Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх" төслийн хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатороор тоноглогдсон, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглах Toyota HiLux болон MAN TGE 3.180 загварын 2 автомашин болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын 5 нэр төрлийн 10 ширхэг анализатор, симуляторын хамт нийлүүлэгдэж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хуваарилсан. Анализатор, симуляторын угсралт суурилуулалт бүрэн хийгдэж, хүлээлгэн өгсөн.	I-IV улирал	100%

14	ЗГҮАХ 2.1.11.1 Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ.	3,635.4	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	2023 онд барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилгын барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна.	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилгын барилга угсралтын ажил дуусч "Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын акт" баталгаажсан. Нэмэлт: "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл"-ийн хүрээнд Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил 50% нүйцэтгэлтэй байна.	I-IV улирал	100%
15	ЗГҮАХ 2.1.11.2 Ховд аймгийн БОЭТ- ийн барилгын өргөтгөл барина.	358.2	Батлагдсан ТЭЗҮ, зураг төсөв	Барилгын ажлын зураг төсөл, төсвийн хөрөнгө шийдвэрлэгдсэн.	Зураг төсөв, ТЭЗҮ-г дуусган, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсан байна.	АХБ-ны "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн 1-р үе шатны хүрээнд Олон улсын зөвлөх фирм International Medical Center ХХК ажиллаж, БОЭТ-ийн нөхцөл байдлын үнэлгээ, шинэ өргөтгөлийн төлөвлөлт хийгдсэн. Өргөтгөлийн үйл ажиллагааны төлөвлөлтийг баталсан. Ховд БОЭТ-д төлөвлөлт, менежментийн сургалтанд давхардсан тоогоор 136 хүн хамрагдсан. Ховд БОЭТ бүтцээ шинэчлэн батласан ТУЗ байгуулах бэлтгэл шатандаа. Барилгын талбай дахь хуучин барилгыг актлахаар ажиллаж байна. Архитектур төлөвлөлтийн даалгавар гарсан (2/21, АТД-84-18/24). Барилгын загвар зургийг батлуулсан. Барилгын дулаан, цэвэр бохир ус, холбооны техникийн нөхцөл гарсан. Барилгын ажлын зураг боловсруулж дуусч байна.	I-IV улирал	80%
16	ЗГҮАХ 2.1.12.1 Эрүүл мэндийн салбарын их засварын шилжих 3, шинэ 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэнэ. /2024 оны төсвийн тухай хуулийн	24,768.6	Их засварын гүйцэтгэлийн хувь	2023 оны жилийн эцсийн байдлаар шилжих их засварын ажлын явц 80%-тай байна.	Засварын ажил дуусч хүлээн авсан байна.	-Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ их засварын хөрөнгө батлагдаж, олон улсын жишигт нийцсэн төрөх тасагтай болох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр эхлүүлсэн. Үүнд:	I-IV улирал	80%

2 дугаар хавсралтын XVIII.2.1- XVIII.2.3/					Багц-1 “ЭХЭМҮТ-ийн төрөх тасгийн засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Эл Эс Би” ХХК шалгарч 1,219.4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2022 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-2 “ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-4/ дотор засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Скудо Тауэр” ХХК шалгарч 1,865.9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-3 “ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-4/ халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир усны шугам сүлжээ, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиоллын шугам сүлжээний засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Алтайнбумбам өргөө” ХХК шалгарч 2,185.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-4 “ЭХЭМҮТ-ийн дулаан дамжуулах төв болон гол дамжуулах шугам хоолойн засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Нэкстстандарт” ХХК шалгарч 2,576.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-5 “ЭХЭМҮТ-ийн Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилгын гадна шугам сүлжээний засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Байгаль Алтай” ХХК шалгарч 151.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 2022 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-6 “ЭХЭМҮТ-ийн Цахилгаан шатны шинэчлэл, засварын ажил”-ын ажлын гүйцэтгэгчээр “Төвхөн Трейд” ХХК шалгарч 3,126.3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2024 онд улсын комисст хүлээлгэн өгсөн. Багц-7 “ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-2, яаралтай тусламж, Гемодиализын тасаг, Хоол боловсруулах эрхтэний эмгэг судлалын тасгийн засвар”,	
--	--	--	--	--	---	--

					мөн “Хүчилтөрөгчийн хийн хангамжийн нэмэлт ажил”-ын засварын гэрээг “Ононбридж” ХХК-тай 2,475.6 тэрбум төгрөгийн дүнтэй байгуулан 2024 онд улсын комисст хүлээлгэн өгсөн. - Багц-8 “ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн байрны засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр “Алтайнбумбат” ХХК-тай 14,599.9 тэрбум төгрөгийн дүнтэй гэрээг байгуулан 2024 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй байна. - Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ төсөл арга хэмжээг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/12 дугаар тоот тушаалаар Сэлэнгэ аймгийн Засаг даргад эрх шилжсэн. Аймгаас худалдан ажиллагаа 5 удаа зарласан боловч 4 удаа амжилтгүй боловч 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Бүрэн-Одод” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. - Эрүүл мэндийн их засвар /Улсын хэмжээнд/- Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, төвсийн тухай хууль, аудитын зөвлөмжийн дагуу нэмэлт ажлын гэрээг “Дэвжих уран өргөө” ХХК-тай байгуулан энэ онд санхүүжих санхүүжилтийг бүрэн олгосон. Ажил нь дуусч хүлээлгэн өгсөн. - Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Е блокийн цэвэр бохир усны шугам сүлжээ болон эрчимт эмчилгээ, дурангийн өрөөний салхивчны их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээний ХАА-г зарласан. - Улсын нэгдүгээр төв эмнэлгийн барилгын гадна их засвар	
--	--	--	--	--	--	--

						/Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлан "Би Рич Трейд" ХХК-тэй 3,284.5 сая төгрөгийн гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн. - Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулиар 3,554.5 сая төгрөг батлагдсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/146, А/245 дугаар тоот тушаалуудаар жагсаалтыг 7 төсөл арга хэмжээгээр баталж, tender.gov.mn цахим системд ажлыг үүсгэн эрүүл мэндийн байгууллагуудад эрх шилжүүлээд байна. Эрх шилжүүлсэн байгууллагуудаас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.		
17	ЗГҮАХ 2.1.12.3 Эрүүл мэндийн салбарын шилжих 41 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. /2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1-XVIII.1.44/	96,917.1	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	Барилга угсралтын ажлын 11 төсөл, арга хэмжээ 90%-аас дээш, 21 төсөл, арга хэмжээ 70-89%-тай, 14 төсөл, арга хэмжээ 40-69%-тай, 6 төсөл, арга хэмжээ 20-39%-тай байна.	Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгасан байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд барилга байгууламжийн 78 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 23 барилга байгууламж ашиглалтад ороод байна. Үлдсэн 55 барилга байгууламжаас ➢ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 11 ➢ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 9 ➢ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 3 ➢ 0-29 хувийн гүйцэтгэлтэй 22 ➢ Худалдан авах ажиллагааны шатанд 10 байна.	I-IV улирал	100%
18	Хүрээ амаржих газрын барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	25,846.7	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2023 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажлын явц 60 хувьтай байна.	Барилга угсралтын ажлыг дуусгаж, Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.	Төсөл, арга хэмжээний "Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын акт" 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн БА-199/2024 дугаартай баталгаажиж, ашиглалтад орсон.	I-IV улирал	100%
19	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нөхөн үржихүй	18,205.8	Барилгын ажлын	2023 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажлын	Барилга угсралтын ажлыг дуусгаж, Улсын	➢ "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ажлын гүйцэтгэл 85	I-IV улирал	90%

91

	болон хүүхдийн зөвлөх поликлиникийн барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.		гүйцэтгэлийн хувь	явц 75 хувьтай байна.	комисст хүлээлгэн өгсөн байна.	%-тай бөгөөд дотор заслын ажил, шалны плитаны ажил гүйцэтгэж байна. ➤ "Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ төсөл, арга хэмжээний "Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын акт" 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн БА-118/2024 дугаартай баталгаажиж, ашиглалтад орсон.		
20	ЗГҮАХ 2.1.12.4 Эрүүл мэндийн салбарын шилжих болон шинэ 43 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг олгоно. /2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.3.1- XVIII.3.43/	1,100.0	Тоног төхөөрөм-жийн хангалтын гүйцэтгэлийн хувь	2023 онд эрүүл мэндийн салбарын шилжих 14 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хэрэгжсэн.	Тоног төхөөрөмжийн хангалт 100%- ийн гүйцэтгэлтэй байна.	1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа 10 хөрөнгө оруулалтын 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2. 2024 онд хэрэгжиж буй 42 төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг шалгаруулах тендер Төрийн худалдан авах ажиллагааны газарт 10 төсөл арга хэмжээ, аймаг нийслэлийн засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн-23, эрүүл мэндийн яаманд -8 төсөл арга хэмжээний тендер зохион байгуулагдан, гэрээг баталгаажуулсан.	I-IV улирал	100%
21	ЗГҮАХ 2.1.14.1, МУТЖҮЧ-2.2 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.	30,387.0	Шинээр орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламж- тай болсон сумын эрүүл мэндийн төвийн тоо	33 сумын эрүүл мэндийн төв сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга 38 батлагдсан.	60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга 38 батлагдсанаас 14 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга ашиглалтад ороод байна. Үлдсэн 24 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилгаас ➤ Худалдан авах ажиллагааны шатанд 4 ➤ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 5 ➤ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 4 ➤ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 2 ➤ 0-29 хувийн гүйцэтгэлтэй 9	I-IV улирал	80%

22	Түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг шинэчилнэ.		Батлагдсан стандарт	2018 онд батлагдсан Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа стандартаар зохицуулагдаж байна.	Сумын эрүүл мэндийн төв болон лавлагаа шатлалд ашиглах түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг боловсруулж батлуулсан байна.	Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, MNS 6717:2018 стандартын В хавсралтаар батлагдсан "Түргэн тусламжийн автомашинд тавих нийтлэг шаардлага"-ыг шинэчлэн сумын эрүүл мэндийн төв болон лавлагаа шатлалд ашиглах түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг төслийг боловсруулж байна.	I-IV улирал	30%
23	Эрүүл мэндийн яамны цахилгааны нөөцийн шугамыг бий болгоно.		Нөөц шугамын тоо		Цахилгааны нөөц шугамыг шинээр бий болгосон байна.	ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 2/1339 албан бичгээр "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д техникийн нөхцөл авахаар хүсэлт хүргүүлсэн боловч олгох боломжгүй гэсэн шийдвэр гарсан. Дахин эх үүсвэр судлуулахаар 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 7/3969 дугаартай "Техникийн нөхцөл хүсэх тухай" албан бичиг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д хүргүүлээд байна. Техникийн нөхцөл авсны дараагаар зураг хийгдэнэ.	I-IV улирал	50%

НЭМЭЛТ АЖИЛ

1	"Түлэнхийн төв байгуулах" төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	70,0 сая төгрөг	Төслийн хэрэгжилт 100%	Төслийн хэрэгжилт 95%	Төслийн хэрэгжилт 100%	Төслийн үлдэгдэл санхүүжилтээр 1 иж бүрдэл унтуулгын авахаар төлөвлөж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/423 дугаар тушаалаар жагсаалт техникийн үзүүлэлтийг батлуулсан. ЭМЯ-ны ТНБДаргын А/134 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан бөгөөд худалдан авалтыг зохион байгуулж, 2024.02.26-нд "Сүвэн-Уул" ХХК-тай "ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж (унтуулгын аппарат) нийлүүлэх" ХО/10 дугаартай гэрээ байгуулагдсан. 2024.03.11-нд тус компани тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн ба	1-6 сар	100%
---	---	-----------------	------------------------	-----------------------	------------------------	--	---------	------

						санхүүжилтийн хүсэлтийн Сангийн яамаар дамжуулан Кувейтийн санд уламжилж, санхүүжилтийг олгосон. Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 2,9 тэрбум төгрөгийн 43 нэр төрлийн 550 тоног төхөөрөмжийг хуваарилах ЭМС-ын тушаалын төсөл боловсруулан хянагдаж байна.			
2	“Хорт навигацийн стереотактик эмчилгээний байгуулах” хэрэгжилтийг байгуулах, тавих	хавдрын болон төв төслийн зохион хяналт	23,3 тэрбум төгрөг	Төслийн хэрэгжилт 100%	Төслийн хэрэгжилт 70%	Төслийн хэрэгжилт 95%	“Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх: Хорт хавдрын навигацийн ба стереотактик эмчилгээний төв байгуулах” төслийн гэрээг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Зээлийн гэрээний бүх нөхцөл хангагдсанаар 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Австрийн UniCredit банк болон Монгол Улсын Сангийн яам хооронд зээлийн гэрээ байгуулагдаж төсөл 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Төслийн хүрээнд нийлүүлэгдэх 18 нэр төрлийн тоног төхөөрөмж бүрийг VAMED Engineering GmbH компани болон ХСҮТ нар хүлээлцэх актаар баталгаажуулан хүлээлцсэн бөгөөд хүлээлцэх ажлууд 2023 оны 5 дугаар сараас эхэлж сүүлийн хоёр төхөөрөмжийн актыг 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдөр баталгаажуулснаар дуусгавар болсон. Эцсийн хэрэглэгчийн талбай дээр бүх сургалтуудыг хийж дууссан. Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 25,2 тэрбум төгрөгийн 20 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хуваарилах ЭМС-ын тушаалын төсөл боловсруулан хянагдаж байна.	1-9 сар	100%
3	“Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх” төслийн хэрэгжилтийг зохион		15,3 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан	Төслийн хэрэгжилт 20%	Төслийн хэрэгжилт 50%	Төслийн хүрээнд БНПУ-ын “Stolarczyk Mirosław Technologia Pozarnicza” компанитай “Supply of customized ambulance in rural areas” МОН/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээ эцэслэн албажих үеэр (2022 оны 02 дугаар сар) КОВИД-19 цар тахлын нөхцөл	1-12	100%

99

байгуулах, тавих	хяналт				байдал, мөн Украин Улсад дайн дэгдсэний улмаас үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт удааширч, инфляцийн түвшин нэмэгдэж, давагдашгүй нөхцөл байдал үүссэн тул гэрээний хэрэгжилт удааширсан. 2023 оны 04 дүгээр сарын байдлаар гэрээний дагуу нийлүүлэгдэх тусгай зориулалтын автомашинууд бэлэн болсон боловч ОХУ-ын нутаг дэвсгэрээр тээвэрлэхэд Украйны дайны нөхцөл байдлын улмаас маш өндөр эрсдэлтэй тул бөгөөд автомашины тээврийн зардал 350,000.0 еврогийн нэмэлт зардал шаардлагатай болох талаар мэдэгдсэн бөгөөд энэ талаар Гадаад харилцааны яам болон Сангийн яаманд хүсэлт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Тогтоолын хавсралтад оруулах тухай” 97 дугаартай тогтоол батлагдаж, үүний дагуу Бүгд Найрамдах Польш Улсын “Stolarczyk Mirosław Technologia Pozarnicza” компанитай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан “Contract agreement No MON/2021-005-0723, Amendment No1” гэрээг байгуулсан. Нэмэлт санхүүжилт батлагдсанаар гэрээний дагуу 35 түргэн тусламжийн автомашин 2023 оны 11 сараас 2024 оны 4 сар хүртэл үе шаттай импортлогдож, нийт 17,5 тэрбум төгрөгийн бүрэн тоноглогдсон 35 түргэн тусламжийн автомашин нийлүүлэгдэж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/116, А/212, А/228, А/229, А/264, А/280, А/327 дугаар тушаалаар 6 төв эмнэлэг, 3 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилагдсан. Гэрээний санхүүжилт 4,150,000.0 еврогийн төлбөрийг зохих журмын дагуу шилжүүлсэн.	
---------------------	--------	--	--	--	---	--

4	“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	36,9 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан	Төслийн хэрэгжилт 10%	Төслийн хэрэгжилт 30%	“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах” төслийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулалтад “Вамед инженеринг” Жи Эм Би Эйч компанийн шалгарсан бөгөөд 2024.01.18-нд “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төсөл”-ийн тоног төхөөрөмж нийлүүлэх ЭМЯ/2023/10/30, Х/06 дугаартай гэрээ байгуулагдсан. Төслийн зээлийн хэлэлцээр байгуулах тухай хүсэлтийг 2024.02.01-нд Сангийн яаманд гэрээний хамт хүргүүлсэн бөгөөд зээлийн хэлэлцээрийн ажлын хэсэгт ажиллаж, 2024.05.01-нд Засгийн газрын хуралдаанаар орж, зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрх олгогдсон. БНАУ-ын талаас зээлийн хэлэлцээрийн 2024 оны 11 сард албажуулсан. Төслийн хүрээний тусгай нөхцлийн дагуу гэрээний урьдчилгаа төлбөр болох 3,0 сая еврогийн төлбөрийг Сангийн яамаар дамжуулан гүйцэтгэгчид олгогдсон. Гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүдөөс эхний ээлжийн 150,9 сая иен буюу 3,4 тэрбум төгрөгийн үнэтэй 3 нэр төрлийн дуран оношилгооны тоног төхөөрөмжүүд Монгол Улсад импортлогдож, гаалийн бүрдүүлэлт хийгдэж байна.	1-12	100%
5	“Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	36,9 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан	Төслийн хэрэгжилт 5%	Төслийн хэрэгжилт 20%	Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголтын банк хоорондын 2019 оны Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих” төслийг хэрэгжүүлэх 43,2 сая ам.долларын зээлийн хэлэлцээр, 5,0 сая еврогийн буцалтгүй тусламжийн гэрээ болон Төслийн гэрээ байгуулагдсан. Европын сэргээн босголтын банкнаас Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн	1-12	100%

					барилга барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) хийх "Green engineering and Finance" зөвлөх компани сонгон шалгаруулж, 29,841 м2 талбайтай, хэвтэн эмчлүүлэгчийн 250 ортой, 33 эмнэлгийн үндсэн нэгж бүхий нэгдсэн эмнэлэг барих ТЭЗҮ боловсруулагдсан. Сангийн яаманд ТХН байгуулах тухай хүсэлт хүргүүлж, Сангийн сайдын 2024.05.28-ны 96 дугаартай "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай" тушаал батлагдсан. ЭМЯ-наас "Төслийн гэрээ"-нд хууль зүйн дүгнэлт гарган, 2/117 дугаартай албан бичгээр ЕСББанкинд хүргүүлсэн. Дархан НЭ-ийн ТЭЗҮ-ийн байгаль орчны үнэлгээнд дүгнэлт гаргуулахаар БОАЖЯам болон Дархан-Уул аймгийн БОАЖГазарт 2/2414, 2/2415 дугаартай албан хүсэлт хүргүүлсэн. ТЭЗҮ-тэй хамт хийгдсэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй танилцаж, Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт" 2024 оны 06 дугаар сарын 04-нд гарсан. ЭМЯ-ны ТНБДаргын 2024.07.26-ны өдрийн А/95 тушаалаар тус төслийн PIS болон PIU сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. 13. ЭМС-ын 2024.07.26-ны өдрийн А/337 тушаалаар "Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих тухай" төслийн Төслийн удирдах хороо байгуулагдсан. "Төслийн хэрэгжилтийн зөвлөх" PIS-ийн сонгон шалгаруулалтыг ЕСББанкны журмаар ЕСЕРР системээр, "Төсөл хэрэгжүүлэгч нэгж"-ийн PIU-ийн сонгон шалгаруулалтыг Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдаж байна. ТХН-ийн 7 ажлын байрыг 2 зарласнаас 3 ажлын байрны сонгон шалгаруулалт	
--	--	--	--	--	--	--

						амжилттай болж, 4 ажлын байрны сонгон шалгаруулалтын дахин зарласан. 2024.12.13-нд материал хүлээж авч, үнэлгээ хийгдэнэ. "Төслийн хэрэгжилтийн зөвлөх" PIS-ийн материалыг 2024.11.25-нд хүлээн авсан бөгөөд 2оролцогч санал ирүүлсэн. Үнэлгээ хийгдэж байна.		
6	"Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл" төслийн хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллах, хяналт тавих	177,1 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан	Хэрэгжилт 20%	Хэрэгжилт 40%	1-р үе шатны төслийн хүрээнд хийгдсэн ажлууд: 1. Сумын эрүүл мэндийн төвүүдийн (СЭМТөв - 4: Хөвсгөл аймаг - Тариалан СЭМТ, Өвөрхангай аймаг - Баян-Өндөр СЭМТ, Дорноговь аймаг - Эрдэнэ СЭМТ, Булган аймаг - Дашинчилэн СЭМТ) барилгын ажлын гүйцэтгэл - 35-92% байна. 2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн (ӨЭМТөв - 2: БЗД-ийн 17-р хорооны ӨЭМТ, ЧД-ийн 19-р хорооны ӨЭМТ) барилгын ажлын гүйцэтгэл 3-10% байна. 3. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлж, угсарч суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийн гэрээ хийгдсэн, тоног төхөөрөмжүүд тээвэрлэлтийн шатандаа явж байна. 4. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн гэрээ байгуулагдсан. Барилгын ажлын гүйцэтгэл 19%-тай байна. 5. Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил 50% нүйцэтгэлтэй байна. 6. Түргэн тусламжийн үндэсний төвийн барилгын ажлын зураг дуусах шатандаа явж байна. 7. Төслийн хүрээнд 37 зөвлөх үйлчилгээг гэрээлсэнээс 5 гэрээ дууссан. Нийт 252 удаагийн сургалтаар 6212 хүнийг сургасан. 2-р үе шатны төслийн зээлийн гэрээг АХБ болон МУЗГ хооронд 2024 оны 11-р сарын 20-нд урагдсан.	1-12	100%

7	Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" төслийн хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллах, хяналт тавих					Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн "Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" төслийн хүрээнд 2024 онд нийт 31,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэгдэж ЭМС-ын 7 тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилагдсан. Үүнд: Автомашин – 55 иж бүрдэл, 23,9 тэрбум төгрөг Тоног төхөөрөмж – 7,8 тэрбум төгрөг (СТ-Компьютерт томографийн аппарат – 3, зөөврийн рентген аппарат -15, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын тоног төхөөрөмж-5 гэх мэт) Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 5,2 тэрбум төгрөгийн 25 автомашины хуваарилалтын тушаалыг боловсруулан хянагдаж байна. Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт дунджаар 86.97 хувьтай байна. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг (КОВИД-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах) - 60 хувьтай, хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг (Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх) – 69 хувьтай, гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг (Хэрэгжүүлэх удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ) – 98.24 хувьтай байна.	100%	
8	"Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах, эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх төсөл MON-9218" төслийн хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллах, хяналт тавих	8,1 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан	Төслийн хэрэгжилт 70%	Төслийн хэрэгжилт 100%	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ны А/96 тушаал - АХБ-ны "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" МОН-9218 төсөл – 5,3 тэрбум төгрөг, 4 иж бүрдэл тусгай зориулалтаар тоноглогдсон явуулын клиникийн автомашинаар хангаж, эрт илрүүлгийн оношилгоонд ашиглагдаж байна.	1-12	100%

					Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 27-ны А/238 тушаал - АХБ-ны "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" МОН-9218 төсөл – 2,88 тэрбум төгрөг, молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмж – ЗӨСҮТ болон 14 салбар ЗСҮТ Буцалтгүй тусламжийн ашиглалт: 97,1 %. Төслийн нийт 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээс өссөн дүнгээр нийт 3.7 сая ам.долларыг зарцуулсан. Төслийн хаалтын огноо 2024.12.31 бөгөөд 2024 оны 09 дүгээр сард АХБ-ны ажлын хэсэг Монгол Улсад ирж төслийн хэрэгжилттэй танилцаж ажиллах үеэр төслийн зарцуулаагүй үлдэгдэл 1.3 сая ам.доллараас 1,024 мянган ам.долларыг дахин хуваарилж шууд гэрээ байгуулах зөвшөөрөл өгсөн. Шууд гэрээг 2024.11.01-нд байгуулсан. Гэрээний гүйцэтгэл 2025 оны 01 дүгээр сард гарна. ЭМЯ-наас 2024.10.31-ний өдөр СЯ руу төслийн хугацааг сунгах хүсэлт хүргүүлсэн. СЯ-наас 2024.11.20-ны өдөр АХБ-нд төслийн хугацааг 3 сараар сунгах хүсэлтийг тус тус хүргүүлээд байна. Одоогийн байдлаар АХБ-наас төслийн хугацааг сунгах зөвшөөрлийг хүлээж байна.	
--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1	Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв авах	Зэрэг дэв авсан байна	-	Зэрэг дэв авсан байна	Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох хүсэлтийн ТАЗ-д хүргүүлж, хянагдан, Ерөнхий сайдын захирамж батлагдсан.	1-12	
2	Сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна	-	Сургалтад хамрагдсан байна	“Төсвийн хөрөнгө оруулалтын шинжилгээ” сургалтад хамрагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн системийн нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан.	1-12	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Т.Хонгорзул /! 

2024-12-10

101